

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ НҮД СОХЛОГЧ ЛАЗЕРИЙН ЗЭВСГИЙН ТУХАЙ ПРОТОКОЛ (IV ПРОТОКОЛ)

1995 оны 10 дугаар сарын 13-ны өдөр баталж, 1998 оны 7 дугаар сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон□

1 дүгээр зүйл

Нүдний харааны хэрэгсэл ашигладаггүй хүний харах эрхтэн, өөрөөр хэлбэл хамгаалалтгүй нүд, эсхүл хараа засах үүрэгтэй харах эрхтнийг бүрмөсөн хараагүй болгох зориулалт бүхий лазерын зэвсгийг зориудаар, эсхүл дайтах ажиллагаанд тусгайлан хэрэглэхийг хориглоно. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд ийм зэвсгийг аль ч улсад, аль ч улс бус байгууллагад дамжуулахгүй.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд лазерын систем хэрэглэвэл харааны хэрэгсэл ашигладаггүй хүний харааны эрхтнийг бүрмөсөн хараагүй болгох явдлаас зайлсхийх арга хэмжээ авна. Урьдчилан сэргийлэх тухайн арга хэмжээнд өөрийн зэвсэгт хүчнийг сургах болон бусад практик арга хэмжээ багтана.

3 дугаар зүйл

Тохиолдлоор сохрох болон лазерын системийг дайны зорилгод, түүний дотор харааны тоног төхөөрөмжийн эсрэг хууль ёсоор хэрэглэснээс үүдэн хараагүй болохыг энэхүү протоколоор хориглосон гэж үзэхгүй.

4 дүгээр зүйл

Энэхүү протоколын зорилгод “бүрмөсөн хараагүй болох” гэж эргэж засашгүйгээр хараагүй болсноос эмчлэгдэшгүй хүнд хэмжээгээр тахир дутуу болохыг хэлнэ. Снеллийн хүснэгтээр хоёр нүдийг нь шалгахад харааны хурц нь 20/200-гаас доош болсныг хүнд хэмжээгээр тахир дутуу болсонд тооцно.